

АМЬД ХРИСТ

Төлөөлөгчдийн Гэрчлэл

Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Исүс Христ хоёр мянган жилийн өмнө мэндэлснийг дурсан хүндэтгэхдээ бид Түүний зүйрлэшгүй амьдрал болон агуу их цагаатгах золиослолын хэмжээлшгүй ач тусын бодит үнэнийг гэрчилдэг. Дэлхий дээр амьдарч байсан ба амьдрах бүх хүмүүст ийм хүчтэй нөлөө хэн ч үзүүлж байгаагүй.

Тэр бол Хуучин Гэрээний Агуу Жэхова, Шинэ Гэрээний Мэссаяа билээ. Тэр бол Эцэгийнхээ удирдлаган дор дэлхийг бүтээсэн Бүтээгч. “Бүх юм Түүгээр бий болсон, Түүнгүйгээр бий болсон юмс нэг ч үгүй” (Иохан 1:3). Нүгэлгүй ч Тэрээр бүх зөв шударга ёсыг гүйцэлдүүлэхээр усаар батлуулсан. Түүнийг “явж сайныг үйлдсэн”-ийх нь төлөө үзэн ядаж байсан. Түүний ариун сургаал бол амар амгалан ба сайн санааны захиас байлаа. Тэр чин сэтгэлээсээ бүгдийг өөрийнх нь жишээг дагахыг хүссэн билээ. Тэрээр Палестины замаар явж өвчтэй нэгнийг анагааж, сохор нэгнийг хараатай болгож, үхсэн нэгнийг амилуулж байв. Тэрээр мөнх байдал, мөнх байдлын өмнөх оршлын бодит үнэнийг, дэлхий дээрх бидний амьдралын зорилго болон ирэх амьдрал дахь Бурханы охид, хөвгүүдэд өгөх боломжийн тухай заасан.

Тэрээр Түүний агуу их цагаатгах золиослолыг сануулахаар ариун ёслолыг тогтоосон. Түүнийг баривчилж гүтгэлгээр ялаж цугларагсдын бахыг ханган шийтгэж Түүнд Калварын загалмай дээр үхэх ял оноосон юм. Тэрээр бүх л хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө амиа өгсөн. Энэ бол хэзээд дэлхий дээр амьдрах бүх хүнд зориулсан Түүний бэлэг билээ.

Бүх хүн төрөлхтний түүхийн төв болж Бэтлэхэмд төрөхөөсөө өмнө ч, мөн Калвараас хойш ч амьдарч буй Түүний амьдралыг бид чин сэтгэлээсээ гэрчилж байна. Тэр бол Эцэгийн ууган, махбодтой Цорын Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч юм.

Тэр бол “нойрсогсдоос эхний үр жимс” болохын тулд үхэгсдээс амилсан юм (1Коринт.15:20). Тэрээр дахин амилсан Их Эзэний хувьд амьдралдаа хайрлаж байсан хүмүүс дээрээ ирсэн. Тэрээр бас эртний Америкт буй “бусад хониндоо” (Иохан 10:16) үйлчлэл үзүүлсэн. Орчин үед эртнээс амласан “цаг хугацааны бүрдлийн эрин үе” -ийг

эхлүүлэхээр Тэр ба Түүний Эцэг Жозеф Смит хүүгийн өмнө гарч ирсэн юм (Эфэс 1:10).

Түүний нүд галын дөл мэт, толгойн үс нь цас мэт цагаан, царай нь нарны туяа мэт гэрэлтэж байв. Тэр бол анхных ба сүүлчийнх, Тэр амьд, алуулсан Тэрээр Эцэгийн өмнө биднийг өмгөөлөх болно гэж хэлэх Жэховагийн хоолойтой адил Түүний хоолой агуу их усны хүнгэнэн урсах чимээ мэт байсан гэж Амьд Христийн тухай бошиглогч Жозеф бичсэн (СбаГ 110:3-4-г үз).

“Аврагчийн тухай олон гэрчлэлийн дараа “Тэр амьд!” гэсэн энэхүү гэрчлэл бол хамгийн сүүлийнх нь юм,” хэмээн бошиглогч бас тунхагласан.

Учир нь бид Түүнийг Бурханы баруун гар талд байхыг харсан ба “Тэр бол Эцэгийн Цорын Ганц Төрсөн Хүү, Түүгээр, Түүгээр дамжуулан, Түүнээс дэлхий ертөнцүүд бүтээгдсэн бөгөөд бүтээгддэг, тэдгээрийн оршин суугчид нь Бурханд төрсөн охид, хөвгүүд нь болдог юм,” хэмээн гэрчлэх дууг бид сонссон (СбаГ 76:22-24-г үз).

“Исүс Христ өөрийн биеэр тулгуур чулуу нь болж төлөөлөгч, бошиглогчдын . . . суурин дээр барьсан” Сүм болон пристийн зэрэг нь дэлхий дээр дахин сэргээгдсэн гэж бид чин сэтгэлийнхээ үгээр мэдэгдэж байна (Эфэс 2:20).

Түүнийг хэзээ нэгэн цагт дэлхий дээр эргэж ирнэ гэж бид гэрчилж байна.

“Дараа нь Эзэний алдар илэрхийлэгдэж бүх махбод хамтдаа Түүнийг үзнэ” (Айзаяа 40:5). Тэрээр Хаадын Хааны хувьд удирдаж Эздийн Эзэний хувьд хаанчлах болно. Тэгээд Түүнийг шүтэн “өвдөг бүхэн сөгдөж хэл бүхнээр ярих болно.” Хүн бүр Түүний өмнө хийсэн ажил хэрэг, зүрх сэтгэлдээ агуулсан хүслийнхээ дагуу шүүгдэх болно.

Бид, Түүний зөв томилсон Төлөөлөгчдийнх нь хувьд Исүс бол амьд Христ, Бурханы үхэшгүй Хүү хэмээн гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд зогсож буй агуу Иммануэл Хаан. Тэр бол дэлхийн гэрэл, амьдрал ба итгэл найдвар. Түүний зам бол энэ амьдралд аз жаргал уруу хөтлөх зам бөгөөд ирэх ертөнцөд мөнхийн амьдрал уруу хөтлөх жим юм. Тэнгэрлэг Хүүгийнх нь зүйрлэшгүй бэлгийнх нь төлөө Бурхандаа талархъя.

ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛ

Thomas M. Monson
James E. Faust

Ш/1, 2000

АРВАН ХОЁРЫН ЧУУЛГА

Boyd K. Packer
L. Tom Perry
Dwight H. Petersen
Neal A. Maxwell
Russell M. Nelson
Dallin H. Oaks

M. Russell Ballard
Joseph B. Wirthlin
Richard G. Scott
Robert D. Hales
Jeffrey R. Holland
Benny D. Eyring

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

